

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: А.Нанжидмаа
Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	17
5.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ГЭРЭЛЦЭЦЭГ ТАНАА

2023.02.18 № УРА-2023/72/НА-СГА ТУС
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3.264,8 мянган төгрөгийг ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, эвдрэл гэмтлийг тогтоосон дүгнэлтгүй Хантер маркын авто машины засварын үнэ 18,000.0 мянган төгрөгийг Засаг дарга нь жолоочтойгоо гэрээ байгуулж шилжүүлсэн нь засвар хийсэн эсэхийг тогтоох боломжгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл "Бусад хангамж" 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр,

0200200272

аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”, УСНББОУС-1 “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь үнэ төлбөргүй авсан 252,341.2 мянга, балансаас балансад 180,465.4 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18,904.0 мянга, нийт 451,710.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,070,948.45	57,743,145.20
33	АВЛАГА	0.00	779,275.00
335	Бусад авлага	0.00	779,275.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	55,440.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	723,835.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,070,948.45	56,963,870.20
354	Хангамжийн материал	30,070,948.45	52,966,537.20
35410	Бичиг хэргийн материал	7,448,108.00	1,368,450.00
35420	Аж ахуйн материал	15,656,490.00	5,787,705.00
35450	Барилгын засварын материал	1,190,000.00	130,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,776,350.45	45,680,382.20
35600	Мал, амьтад	-	3,997,333.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,317,836,497.87	1,494,982,892.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,317,836,497.87	1,494,982,892.62
392	Биет хөрөнгө	1,234,866,497.87	1,410,848,892.58
39201	Барилга, байгууламж	1,047,828,273.08	1,365,336,681.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-378,311,549.40	-525,801,000.09
39203	Авто тээврийн хэрэгсэл	216,128,600.00	266,528,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,090,878.19	-70,783,211.52
39205	Машин, тоног төхөөрөмж	535,593,260.20	580,927,474.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-291,214,657.36	-343,522,778.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,623,539.97	43,057,139.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,537,169.78	-30,075,085.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	225,038,689.00	253,038,689.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-98,191,609.65	-127,857,616.83
393	Биет бус хөрөнгө	82,970,000.00	84,134,000.04
39301	Програм хангамж	3,055,000.00	3,055,000.00
39302	Хасагдуулга	-2,305,000.00	-2,554,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	82,220,000.00	83,634,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,347,907,446.32	1,552,726,037.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,347,907,446.32	1,552,726,037.82
51	Засгийн газрын хувь оролцоо	1,347,907,446.32	1,552,726,037.82
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	746,186,599.17	746,186,599.17
51101	Өмч: -Төрийн өмч	746,186,599.17	746,186,599.17
512	Хуримтлагдсан үр дүн	300,668,674.37	505,487,265.87
51210	Өмнөх үеийн үр дүн	300,668,674.37	300,668,674.37
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	204,818,591.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	301,052,172.78	301,052,172.78
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,347,907,446.32	1,552,726,037.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	830,102,912.00	918,216,933.92
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	323,537,600.00	390,894,433.92
	Нийтлэг татварын бус орлого	323,537,600.00	390,894,433.92
120017	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	-	340,045,515.23
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	323,537,600.00	50,848,918.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,939,500.00	8,042,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	317,598,100.00	42,806,418.69
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	506,565,312.00	527,322,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,548,812.00	3,870,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	7,446,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	57,250,000.00	3,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	852,812.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	441,016,500.00	523,452,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	441,016,500.00	523,452,500.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	611,343,512.20	713,398,342.42
	УРСГАЛ ЗАРДАЛ	590,843,512.20	713,398,342.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,853,092.75	641,681,474.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	262,573,214.08	257,221,731.05
210101	Цалин	218,602,839.77	198,694,274.46
210102	Нэмэгдэл цалин	-	30,180,848.46
210104	Урамшуулал	-	5,748,174.00
210105	Гэрээтийн цалин	43,970,374.31	22,598,434.13
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,119,984.37	31,731,389.41
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,176,225.07	21,678,187.79
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,606,819.45	2,572,063.76
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,039,697.76	2,072,579.22
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	476,260.17	491,687.05
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,820,981.92	4,916,871.59
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,413,314.20	37,692,336.84
210301	Гэрэл цахилгааны зардал	1,830,784.32	6,972,202.04
210302	Түлш, халаалтын зардал	36,582,529.88	30,720,134.80
	Хангамж, бараа материалын зардал	23,269,779.90	56,141,534.90
210401	Бичиг хэргийн материал	2,361,100.00	9,432,558.00
210402	Тээвэр, шатахууны зардал	16,804,480.00	33,434,040.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,730,199.90	1,718,651.90
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	160,000.00	1,620,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,214,000.00	9,936,285.00
	Нормативт зардал	500	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,793,500.00	52,790,000.00
210601	Багаж хэрэгсэл	206,000.00	-
210604	Урсгал засвар	2,587,500.00	52,790,000.00
	Томиллот, зочны зардал	4,135,000.00	6,216,000.00
210702	Дотоод томиллотын зардал	4,135,000.00	6,216,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	31,643,189.55	1,741,648.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,102,811.55	-
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	89,100.00	63,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,974.00	111,542.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	162,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	330,000.00	363,000.00
210807	Газрын төлбөр	752,304.00	752,856.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,904,610.65	196,646,834.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,309,110.00	14,414,660.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	380,800.00	1,448,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,214,700.65	180,784,174.42
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,990,419.45	71,716,867.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,483,384.00	25,830,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	829,984.00	9,093,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,507,035.45	45,885,967.80
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,507,035.45	45,885,967.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,500,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	20,500,000.00	-
223001	Бусад хөрөнгө	20,500,000.00	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	218,759,399.80	204,818,591.50
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	218,759,399.80	204,818,591.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	516,504,812.00	535,365,000.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,939,500.00	8,042,500.00
	Нийтлэг татварын бус орлого	5,939,500.00	8,042,500.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,939,500.00	8,042,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,939,500.00	8,042,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,565,312.00	527,322,500.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,548,812.00	3,870,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	7,446,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	57,250,000.00	3,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,852,812.00	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	441,016,500.00	523,452,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	441,016,500.00	523,452,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	467,004,812.00	524,865,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,004,812.00	524,865,000.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,014,392.55	451,986,932.20
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	262,573,214.08	257,954,264.92
210101	Үндсэн цалин	218,602,839.77	194,254,700.11
210102	Нэмэгдэл	-	33,592,678.03
210104	Үр дүнгийн урамшуулал	-	5,748,174.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,970,374.31	24,358,712.78

2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,119,984.37	31,778,130.54
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,176,225.07	21,724,928.92
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,606,819.45	2,572,063.76
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,039,697.76	2,072,579.22
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	476,260.17	491,687.05
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,820,981.92	4,916,871.59
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	38,413,314.20	37,692,336.84
210301	Гэрэл цахилгааны зардал	1,830,784.32	2,583,611.24
210302	Түлш, халаалтын зардал	36,582,529.88	35,108,725.60
2104	Хангамж, бараа материалын зардал	23,269,779.90	23,259,821.90
210401	Бичиг хэрэг	2,361,100.00	1,245,900.00
210402	Тээвэр, шатахуун	16,804,480.00	17,944,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,730,199.90	1,718,651.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	1,620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,214,000.00	730,950.00
	Нормативт зардал	416,500.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	416,500.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,753,500.00	60,390,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	586,000.00	6,100,000.00
210604	Урсгал засвар	11,167,500.00	54,290,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,135,000.00	6,216,000.00
210702	Дотоод албан томилолт	4,135,000.00	6,216,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,643,190.00	2,041,648.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,102,812.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	63,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,974.00	111,542.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	162,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	363,000.00
210807	Газрын төлбөр	752,304.00	752,856.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	62,689,910.00	31,154,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,309,110.00	29,416,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,800.00	1,738,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,990,419.45	72,878,067.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,483,384.00	26,992,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	11,653,400.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	829,984.00	10,254,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,507,035.45	45,885,967.80
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,507,035.45	45,885,967.80
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	49,500,000.00	10,500,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	49,500,000.00	10,500,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,500,000.00	10,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,500,000.00	10,500,000.00
223001	Бусад хөрөнгө	49,500,000.00	10,500,000.00

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(49,500,000.00)	(10,500,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	750,442,599.17	346,823,597.18	141,428,361.40	1,238,694,557.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	45,619.80	45,619.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	750,442,599.17	346,823,597.18	141,473,981.20	1,238,740,177.55
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-45,619.80	0	-45,619.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	183,897,833.34	183,897,833.34
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	750,442,599.17	346,777,977.38	325,371,814.54	1,422,592,391.09
11	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	750,442,599.17	346,777,977.38	325,371,814.54	1,422,592,391.09
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,256,000.00	-45,725,804.60	-24,703,140.17	-74,684,944.77
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	746,186,599.17	301,052,172.78	300,668,674.37	1,347,907,446.32
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	204,818,591.50	204,818,591.50
20	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	746,186,599.17	301,052,172.78	505,487,265.87	1,552,726,037.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	526,710,900.00	485,609,032.20	41,101,867.80	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,210,900.00	475,109,032.20	41,101,867.80	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,640,600.00	448,116,932.20	40,523,667.80	91.7

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,427,600.00	257,954,264.92	10,473,335.08	96.1
210101	Үндсэн цалин	243,227,600.00	194,254,700.11	48,972,899.89	79.9
210102	Нэмэгдэл	0	33,592,678.03	-33,592,678.03	0.0
210104	Урамшуулал	0	5,748,174.00	-5,748,174.00	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	24,358,712.78	841,287.22	96.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,553,600.00	31,778,130.54	1,775,469.46	94.7
210201	Тэтгэврийн даатгал	22,816,300.00	21,724,928.92	1,091,371.08	95.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,300.00	2,572,063.76	112,236.24	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,147,500.00	2,072,579.22	74,920.78	96.5
210204	Ажилгүйдлийн даатгал	536,900.00	491,687.05	45,212.95	91.6
210205	Эрүүл мэндийн даатгал	5,368,600.00	4,916,871.59	451,728.41	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,128,800.00	37,692,336.84	1,436,463.16	96.3
210301	Гэрэл, цахилгаан	3,112,000.00	2,583,611.24	528,388.76	83.0
210302	Түлш, халаалт	36,016,800.00	35,108,725.60	908,074.40	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,453,300.00	22,039,821.90	4,413,478.10	83.3
210401	Бичиг хэрэг	1,593,600.00	1,245,900.00	347,700.00	78.2
210402	Тээвэр, шатахуун	16,840,600.00	16,724,320.00	116,280.00	99.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,917,600.00	1,718,651.90	198,948.10	89.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,140,000.00	1,620,000.00	3,520,000.00	31.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	961,500.00	730,950.00	230,550.00	76.0
2105	Нормативт зардал	1,530,500.00	1,500,000.00	30,500.00	98.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,530,500.00	1,500,000.00	30,500.00	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,907,500.00	60,390,000.00	5,517,500.00	91.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,839,500.00	6,100,000.00	4,739,500.00	56.3
210604	Урсгал засвар	55,068,000.00	54,290,000.00	778,000.00	98.6
2107	Томилолт, зочны зардал	6,676,600.00	6,216,000.00	460,600.00	93.1
210702	Дотоод албан томилолт	6,676,600.00	6,216,000.00	460,600.00	93.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,730,400.00	1,741,648.00	1,988,752.00	46.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,000.00	0	650,000.00	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	288,000.00	2,000.00	99.3
210803	Даатгалын үйлчилгээ	341,200.00	63,750.00	277,450.00	18.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	575,800.00	111,542.00	464,258.00	19.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	208,000.00	162,500.00	45,500.00	78.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	665,400.00	363,000.00	302,400.00	54.6
210807	Газрын төлбөр	1,000,000.00	752,856.00	247,144.00	75.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,232,300.00	28,804,730.00	14,427,570.00	66.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,815,800.00	28,416,730.00	14,399,070.00	66.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	388,000.00	28,500.00	93.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,570,300.00	26,992,100.00	578,200.00	97.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,570,300.00	26,992,100.00	578,200.00	97.9

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,833,000.00	10,254,800.00	578,200.00	94.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,500,000.00	10,500,000.00	0.00	100.0
223001	Бусад хөрөнгө	10,500,000.00	10,500,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	526,710,900.00	531,495,000.00	-4,784,100.00	100.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	524,710,900.00	523,452,500.00	1,258,400.00	99.8
320001	Орон нутгийн төсвөөс	524,710,900.00	523,452,500.00	1,258,400.00	99.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	8,042,500.00	-6,042,500.00	402.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	8,042,500.00	-6,042,500.00	402.1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	8	8	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	9	9	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	3,870,000.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	0	3,870,000.00
Бараа, үйлчилгээний зардал	0	3,870,000.00
Хангамж, бараа материалын зардал	0	1,220,000.00
Тээвэр (шатахуун)	0	1,220,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	0	300,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	300,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0	2,350,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0	1,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	1,350,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	3,870,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0	3,870,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	3,870,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 204,818.5 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	779.2	779.2
Бараа материал	30,070.9	56,963.8	26,892.9
Үндсэн хөрөнгө	1,317,836.4	1,494,982.8	177,146.3
Нийт хөрөнгө	1,347,907.4	1,552,726.0	204,818.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,317,836.4	1,494,982.8	177,146.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,347,907.4	1,552,726.0	204,818.5

Авлага дансны үлдэгдэл 779.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 56,963.8 мянган төгрөг болж 26,892.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын нөөцийн өвс, тэжээл бэлтгэж нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,494,982.8 мянган төгрөг болж 177,146.3 мянган төгрөгөөр өссөн нь 432,806.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан болон балансаас балансад шилжүүлэн авсан хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,494,982.8 мянган төгрөг болж 177,146.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон төсвөөс 455,603.7 мянга, давсан орлогоос 2,000.0 мянга, нийт 457,603.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 55,341.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 512,944.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 13,765.2 тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 524,710.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянга, нийт 526,710.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 523,452.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 485,609.0 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь үндсэн данс хэмнэгдсэн байна. Үндсэн данснаас 41,101.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	220,970.2	212,994.6	7,975.6	96.4
2	Баг хорооны үйл ажиллагаа	105,312.0	97,539.0	7,773.0	92.6
3	Төрийн өмчит барилгын тогтмол зардал	74,913.0	73,919.2	993.8	98.7
4	Нийтлэг үйлчилгээ	37,899.6	32,787.3	5,112.3	86.5
5	Мэдээлэл сурталчилгаа	250.0		250.0	-
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж	10,833.0	10,254.8	578.2	94.7
7	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж	16,737.3	16,737.3	-	100.0
8	Орон нутгийн нөөц хөрөнгө	18,735.0	17,907.7	827.3	95.6
9	Мал тооллого	2,400.0	2,400.0	-	100.0
10	Байгаль орчноос хамгаалах нөхөн сэргээх	18,420.8	4,350.0	14,070.8	23.6
11	Хур хог хаягдал орчны бохирдол цэвэрлэх	5,140.0	1,620.0	3,520.0	31.5
12	Улсын их баяр наадам	4,000.0	4,000.0	-	100.0
13	Ахмадын сан	600.0	599.0	1.0	99.8
14	Бусад хөрөнгө	10,500.0	10,500.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,870.0 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,220.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 300.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,350.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 611,343.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,113.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 713,398.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 7,133.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,080.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл “Бусад хангамж” 12.1.4 4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг зөрчин ажилчдын аялал зугаалгын зардлыг төсвөөс гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	4,000.0	1	4,000.0	100
Нийт дүн	1	4,000.0	1	4,000.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 170,983.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 149,699.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 3,284.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 18,000.0 төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орон нутгийн төсвийн санхүүжилтийг 84,539.0 мянга, зарлага цэвэр зээлийн дүнг 53,160.0 мянга, нийт 137,699.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг аудитын явцад залруулга хийлгэв.
2. Үнэ төлбөргүй ирсэн 12,000.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад залруулга хийлгэв.

5.1 Төлбөрийн акт

Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3.264,8 төгрөгийг ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1. дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

5.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

Өндөрхангай сумын Засаг дарга нь Засаг даргын тамгын газрын жолоочтойгоо Хантер маркын авто машинд засвар хийлгэх зорилгоор гэрээ байгуулж, жолоочийн данс руу 18,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Хантер маркын машины эвдрэл гэмтлийг тогтоосон авто засварын газрын оношилгооны дүгнэлт байхгүй, засвар үйлчилгээ хийсэн эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Зам тээврийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлан дутуу илэрхийлсэн	2	137,699.0			2	137,699.0	2	137,699.0				
Шинээр нэмэгдсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй	1	12,000.4	1	12,000.4			1	12,000.4				
Дүн	3	149,699.0	1	12,000.4	2	137,699.0	3	149,699.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аялал зугаалгад зориулж төсвөөс зардал гаргасан	1	3,284.0	1	3,284.0								
Хантер маркын машинд засвар үйлчилгээ хийсэн үнэн зөвийг тогтоож боломжгүй	1	18,000.0									1	18,000.0
Дүн	2	21,284.0	1	3,284.0							1	18,000.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /А.НАНЖИДМАА/

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 01/07/А 2070416

Улаангом

УВА-2023/12/А-СГА-ТЦБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3 264 800 төгрөгийг ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл “Бусад хангамж” 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 3 264 800 /Гурван сая хоёр зуун жаран дөрвөн мянга найман зуун/ төгрөгийг Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Гэрэлцэцэгээр төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Өндөрхангай сумын Засаг дарга Г.Төмөрчөдөр, Засаг даргын тамгын газрын дарга Б.Гэрэлцэцэг, нягтлан бодогч Г.Соёл-эрдэнэ нарт хариуцуулав.


¹Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200500024

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



А.НАНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

